

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР



СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн эдийн засаг,
нийгмийн байдал

2018\10

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	2
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	3
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 ЭРҮҮЛ МЭНД	7
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	13
 ТӨСӨВ	16
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	19
 ГАЗАР ТАРИАЛАН	28
 АЖ ҮЙЛДВЭР	28
 ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	33
 ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ	34
 БАРИЛГА	36
 ХАРИЛЦАА ХОЛБОО	39
 ДОТООД ХУДАЛДАА	40

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн X сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018
Шинээр төрсөн хүүхэд	тоо	34 924 ↑5.1	34 711 ↓0.6	34 244 ↓1.3	31 566 ↓7.8	33 824 ↑7.1
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	14 918 ↑14.6	11 531 ↓22.8	11 365 ↓0.9	6 847 ↓40.4	10 342 ↑51.0
Үүнээс: эмэгтэй	хүн	8 286 ↑13.7	6 523 ↓21.7	5 896 ↓9.2	3 867 ↓33.9	5 575 ↑44.2
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	14 947 ↓2.7	35 698 ↑138.8	35 458 ↓0.7	22 941 ↓35.3	19 064 ↓116.9
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	13 998 ↑9.1	15 005 ↑7.2	15 257 ↑1.7	17 734 ↑16.2	22 422 ↑26.4
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.8 ↓0.5	-1.1 ↓1.9	-1.2 ↓0.1	0.4 ↑1.6	1.2 ↑0.8
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	1 862 ↑8.5	1 992 ↑7.0	2 374 ↑19.2	2 456 ↑3.4	2 564 ↑4.4
Нийслэлийн төсвийн орлого	тэрбум төгрөг	652.0 ↑17.4	652.2 =0.0	683.9 ↑4.9	552.8 ↓19.1	690.6 ↑24.9
Нийслэлийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	533.3 ↑14.6	688.9 ↑29.2	761.9 ↑10.6	751.5 ↓1.4	973.0 ↑29.5

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ↑, ↓ эерэг өөрчлөлтийн хувь;
↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
= тогтвортой

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны X сард					2018 оны X сард				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	тоо	298	Баянгол	7 389	Налайх	54	306	Баянгол	7 630	Налайх	54
			Чингэлтэй	1 797	Багануур	47		Чингэлтэй	1 808	Багануур	47
			Сүхбаатар	138	Багахангай	30		Сүхбаатар	671	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	79	Багахангай	621	Хан-Уул	67	115	Багахангай	574	Хан-Уул	70
			Багануур	283	Чингэлтэй	64		Багануур	212	Налайх	61
			Сүхбаатар	132	Сонгинохайрхан	59		Баянзүрх	189	Баянгол	56
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Багахангай	25	Баянзүрх	11	11	Налайх	14	Чингэлтэй	10
			Налайх	15	Чингэлтэй	7		Багахангай	14	Баянзүрх	10
			Багануур	14	Баянгол	6		Хан-Уул	11	Баянгол	9
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчид	0\000	168	Баянзүрх	190	Багануур	122	115	Багануур	161	Сонгинохайрхан	103
			Сүхбаатар	149	Налайх	118		Баянзүрх	146	Сонгинохайрхан	100
			Чингэлтэй	146	Багахангай	34		Сүхбаатар	111	Багахангай	29
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	мянган төгрөг	74	Чингэлтэй	99	Багануур	10	71	Сүхбаатар	75	Багануур	13.1
			Сүхбаатар	73	Налайх	8		Чингэлтэй	66	Налайх	10
			Хан-Уул	43	Багахангай	6		Хан-Уул	55	Багахангай	6
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	192	Сүхбаатар	324	Хан-Уул	142	238	Сүхбаатар	409	Сонгинохайрхан	147
			Баянзүрх	218	Багахангай	117		Баянзүрх	296	Багануур	112
			Чингэлтэй	208	Багануур	114		Баянгол	265	Багахангай	86


Тайлбар: * - промилль ** - продицимль



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2018 оны 10 дугаар сарын эцэст 10342 болж, өмнөх оны мөн үеэс 3495 (51.0%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 5575 (53.9%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Бүртгэлтэй ажилгүй иргэд, нийслэлийн дүнд эзлэх хувь




Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүй иргэдийн 4171 (40.3%) нь 25-34 насныхан эзэлж байгаа бол 2684 (26.0%) нь 35-44 насны, 2048 (19.8%) нь 45-аас дээш насны, 1439 (13.9%) нь 15-24 насны залуучууд байна.

Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4099 (39.6%) нь Баянзүрх, 1763 (17.1%) нь Сонгинохайрхан, 1279 (12.4%) нь Чингэлтэй, 1007 (9.7%) нь Сүхбаатар, 783 (7.6%) нь Баянгол, 732 (7.1%) нь Хан-Уул, 393 (3.8%) нь Багануур, 147 (1.4%) нь Багахангай, 139 (1.3%) нь Налайх дүүрэгт тус тус амьдарч байна.

Дүүргүүдийн хөдөлмөрийн албанд 2018 оны 10 дугаар сард 4142 хүн ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 616 (17.5%) хүнээр өссөн байна. Ажилд орохоор шинээр бүртгүүлсэн иргэдээс 610 (14.7%) нь сургууль төгсөөд ажилгүй байгаа, 549 (13.2%) нь шилжин суурьшсан, 2741 (66.2%) нь ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан, үлдсэн 242 (5.8%) нь бусад шалтгаанаар ажил хайж байна.

Зураг 2. Дүүргийн хөдөлмөрийн албадад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажил хайж буй шалтгаанаар, нийслэлийн дүнд эзлэх хувь



Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2016	2017	2018	2016	2017	2018
Ажилгүйчүүд, бүгд	11 365	6 847	10 342	100.0	100.0	100.0
Үүнээс:						
Дээд боловсролтой	4 908	3 327	4 374	36.1	48.6	42.3
Тусгай дунд боловсролтой	664	321	459	6.8	4.7	4.4
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	560	227	370	4.7	3.3	3.6
Ерөнхий боловсролтой	5 174	2 920	5 029	51.8	42.6	48.6
Мэргэжилгүй	59	52	110	0.6	0.8	1.1

2018 оны 10 дугаар сард бүртгэлтэй ажилгүй 2717 иргэн бүртгэлээс хасагдсаны 1612 нь ажилд зуучлагдан орсон байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 10 дугаар сард хөдөлмөрийн албадаар зуучлагдан ажилд орсон 1612 хүний 19 (1.2%) нь улсын үйлдвэрийн газарт, 7 (0.4%) төрийн бус байгууллагад, 141 (8.7%) нь төсөвт байгууллагад, 1445 (89.6%) нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.




НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний 10 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 27.9 мянган байгууллагын 659.7 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 456.8 мянга (69.3%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 116.3 мянга (17.6%) нь төсөвт байгууллагын, 86.6 мянга (13.1%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 52.8 мянган хүнээр (8.7%) нэмэгджээ.


Зураг 3. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд 2018 оны эхний 10 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 110.7 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 760.4 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 78.5% нь тэтгэврийн даатгалын санд, 10.1% нь тэтгэмжийн даатгалын санд, 9.3% нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 2.1% нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 4. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас 2018 оны эхний 10 сард даатгуулагч, иргэдэд 1092.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 69.8 хувийг тэтгэврийн, 15.1 хувийг эрүүл мэндийн, 6.8 хувийг ҮОМШӨ-ний, 6.3 хувийг тэтгэмжийн, 2.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2018 оны 10 дугаар сард 166.1 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 762.3 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс тэтгэвэр олголттой холбоотой гарсан зардалд 149.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Зураг 5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 123.8 мянган хүнд 466.1 тэрбум (74.5%) төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй тэтгэвэр авагч 23.5 мянган иргэнд 60.4 тэрбум (14.2%) төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 7.2 мянган хүнд 19.0 тэрбум (4.3%) төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 11.6 мянган хүнд 67.1 тэрбум (7.0%) төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 67.2 мянган хүнд 9.3 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 30.5 мянган хүнд 42.8 тэрбум төгрөгийг, 4.8 мянган хүнд оршуулгын тэтгэмж болгож 4.8

тэрбум төгрөгийг тус тус олгожээ. Тэтгэмж олгохтой холбоотой гарсан бусад зардалд зориулж 2018 оны эхний 10 сард нийтдээ 12.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.



ЭРҮҮЛ МЭНД

2018 оны эхний 10 сард 33824 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 2258 хүүхдээр (7.2%) өссөн байна. Төрсөн нийт хүүхдийн 6146 (18.2%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


Хүснэгт 4. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 10 сард

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	2018 I-X	$\frac{2018}{2017}$ %
Амаржсан эхийн тоо	34 036	31 317	33 537	107.1
Амьд төрсөн хүүхэд	34 244	31 566	33 824	107.2
Эхийн эндэгдэл	14	9	9	100.0
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	525	420	451	107.4
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэлх насанд эндсэн хүүхэд	15.3	13.3	13.3	100.0

Нялхсын эндэгдлийн 67 (14.9%) нь Сонгинохайрхан, 65 (14.4%) нь Баянзүрх, 43 (9.5%) нь Хан-Уул, 41 (9.1%) нь Баянгол, 32 (7.1%) нь Чингэлтэй, 25 (5.5%) нь Сүхбаатар, 10 (2.2%) нь Налайх, 6 (1.3%) нь Багануур, 1 (0.2%) нь Багахангай дүүрэгт, 161 (35.7%) нь бусад аймгийн харьяат байна.

Нийслэлд 2018 оны эхний 10 сард 19064 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 3877 (16.9%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 32.0 продицимилээр буурсан байна.

Зураг 6. Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 4528 (23.8%) нь цусан суулга, 3655 (19.2%) нь салхин цэцэг, 2285 (12.0%) нь тэмбүү, 1784 (9.4%) нь сүрьеэ, 1576 (8.3%) нь гар хөл амны өвчин, 1704 (8.9%) нь трихомониаз, 1512 (7.9%) нь заг хүйтэн, 694 (3.5%) нь улаан эсэргэнэ, 280 (1.5%) сальмонеллёз, 268 (1.4%) нь хоолны хордлого, 247 (1.3%) нь вируст хепатит, 166 (0.9%) гахайн хавдар, 238 (1.2%) нь бусад өвчнөөр өвчлөгчид түс түс эзэлж байна.

Хүснэгт 5. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 10 сард

Төрөл	Хэмжих нэгж	2016 I-X	2017 I-X	2018 I-X	Өсөлт, бууралт 2018/2017	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	35 458	22 941	19 064	-3 877	83.2
	10000 хүнд	266.6	168.3	136.3	-32.0	
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо	286	262	247	-15	-4.7
	10000 хүнд	2.2	1.7	1.6	-0.1	
Цусан суулга	бодит тоо	2 113	2 473	4 083	1 610	65.1
	10000 хүнд	13.9	18.1	29.2	11.1	
Салхин цэцэг	бодит тоо	2 256	4 827	3 315	-1 512	-31.3
	10000 хүнд	17.0	35.4	23.7	-11.7	
Гахай хавдар	бодит тоо	179	90	131	41	45.6
	10000 хүнд	1.3	0.7	0.9	0.2	
Сальмонеллөз	бодит тоо	118	117	266	149	127.4
	10000 хүнд	0.9	0.9	1.9	1.0	
Улаан эсэргэнэ	бодит тоо	827	1 353	600	-753	-55.7
	10000 хүнд	6.2	9.9	4.3	-5.6	
Улаан бурхан	бодит тоо	15 961	7	-	-	-
	10000 хүнд	120.0	0.1	-	-	
Хоолны хордлого	бодит тоо	340	76	249	173	227.6
	10000 хүнд	2.6	0.6	1.8	1.2	
Ёлом	бодит тоо	91	142	80	-62	-43.7
	10000 хүнд	0.7	1.0	0.6	-0.5	
Бруцеллөз	бодит тоо	16	25	10	-15	-60
	10000 хүнд	0.1	0.2	0.1	-0.1	
Гар хөл амны өвчин	бодит тоо	4 188	3 615	1 502	-2 113	-58.5
	10000 хүнд	31.5	26.5	10.7	-15.8	
Тэмбүү	бодит тоо	2 218	2 312	2 023	-289	-12.5
	10000 хүнд	16.7	17.0	14.5	-2.5	
Заг хүйтэн	бодит тоо	1 434	1 314	1 346	32	2.4
	10000 хүнд	10.8	9.6	9.6	-	
Трихомониаз	бодит тоо	1 510	1 508	1 506	-2	-0.1
	10000 хүнд	11.4	11.1	10.8	-0.3	
Сүрьеэ	бодит тоо	2 012	1 810	1 620	-190	-10.5
	10000 хүнд	15.1	13.3	11.6	-1.7	
ДОХ	бодит тоо	19	21	16	-5	-23.8
	10000 хүнд	0.1	0.2	0.1	-0.1	
Бусад	бодит тоо	413	1 269	224	1 045	82.3



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2018 оны 10 дугаар сард дунджаар 2.8°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.1°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал 2.2°C -аар тус тус дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 18.3°C , хамгийн хүйтэн хэм -10.6°C , хүр тунадасны нийлбэр 7.3 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 15 метр секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 өдөр бүртгэгдсэн байна.


Хүснэгт 6. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$, X сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.050	282	0.083	6	0.014
Азотын давхар исэл	NO_2	0.050	310	0.118	73	0.038
Тоосжилт	PM_{10}	0.100	294	0.384	202	0.128
	$\text{PM}_{2.5}$	0.050	191	0.130	72	0.049
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	592	5.818	-	0.999
Озон	O_3	0.100	542	0.074	-	0.024

2018 оны 10 дугаар сард хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж I хороолол орчимд 3 удаа, зурагт орчимд 3 удаа, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 21 удаа, I хороолол орчимд 11 удаа, XIII хороолол орчимд 26 удаа, Зуун айл орчимд 1 удаа, Хар хорин зах орчимд 8 удаа, Толгойтод 1 удаа, Зурагт орчимд 5 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун 4 зам орчимд 23 удаа, I хороолол орчимд 18 удаа, XIII хороолол орчимд 21 удаа, Зуун айл орчимд 26 удаа, Хар хорин зах орчимд 26 удаа, Ургах наран хороолол орчимд 10 удаа, Нисэх орчимд 21 удаа, Толгойт орчимд 12 удаа, Зурагт орчимд 22 удаа, Амгалан орчимд 23 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 7. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, $\text{мг}/\text{м}^3$




¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар


² 8 цагийн дундаж

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.


Зураг 8. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 9. Улаанбаатар³ хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 10. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд амоны азот 1.8 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.7 дахин хүлцэх хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой байна.

Хүснэгт 7. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, X сард⁴

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.69	Хэвийн	9.64	Хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤3	0.6	Хэвийн	5.2	1.7 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤0.02	0.001	Хэвийн	0.019	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.06	Хэвийн	0.89	1.8 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.003	Хэвийн	0.066	Хэвийн

⁴ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 8. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, X сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	I хороолол	XIII хороолол	Зуун айл	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Зурагт	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж		0.008	0.035	0.013	0.009	0.003		-	0.003	0.025	0.030	0.007
	Хамгийн их		0.020	0.083	0.027	0.020	0.009		-	0.007	0.044	0.054	0.014
	XXX*-с давсан хувь		0.0	10.0	0.0	0.0	0.0	0.008	-	0.0	0.0	10.0	0.0
	Хэмжилтийн тоо		20	31	31	31	30	0.018	-	31	15	31	31
Азотын давхар исэл NO ₂	Дундаж		0.094	0.043	0.069	0.032	0.016	0.0	0.009	0.012	0.033	0.036	0.028
	Хамгийн их		0.118	0.062	0.090	0.055	0.037	31	0.016	0.022	0.052	0.058	0.050
	XXX*-с давсан хувь		100.0	36.0	84.0	4.0	0.0	0.041	0.0	0.0	7.0	16.0	0.0
	Хэмжилтийн тоо		21	31	31	28	29	0.064	31	31	15	31	31
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж		1.313	1.558	1.026	0.667	-	31	0.127	-	1.615	-	-
	Хамгийн их		5.818	4.054	2.875	3.051	-	0.686	0.263	-	3.812	-	-
	XXX*-с давсан хувь		0.0	0.0	0.0	0.0	-	2.691	0.0	-	0.0	-	-
	Хэмжилтийн тоо	Хэмжилт хийгдээгүй	93	93	93	85	-	0.0	93	93	42	-	-
Тоос PM ₁₀	Дундаж		0.126	0.113	0.123	0.158	-	0.161	0.091	0.127	0.135	0.128	0.122
	Хамгийн их		0.198	0.205	0.199	0.384	-	0.287	0.201	0.241	0.222	0.210	0.209
	XXX*-с давсан хувь		74.0	58.0	68.0	84.0	-	84.0	32.0	68.0	80.0	71.0	74.0
	Хэмжилтийн тоо		31	31	31	31	-	31	31	31	15	31	31
Тоос PM _{2.5}	Дундаж		0.038	0.052	0.032	-	-	-	-	0.044	0.076	0.064	0.038
	Хамгийн их		0.086	0.105	0.105	-	-	-	-	0.071	0.130	0.127	0.083
	XXX*-с давсан хувь		13.0	52.0	19.0	-	-	-	-	42.0	80.0	64.0	19.0
	Хэмжилтийн тоо		31	21	31	-	-	-	-	31	15	31	31
Озон O ₃ **	Дундаж		-	0.008	0.016	0.020	-	-	0.031	0.021	-	0.026	0.045
	Хамгийн их		-	0.014	0.037	0.057	-	-	0.056	0.037	-	0.050	0.074
	XXX*-с давсан хувь		-	0.0	0.0	0.0	-	-	0.0	0.0	-	0.0	0.0
	Хэмжилтийн тоо		-	93	93	93	-	-	47	93	-	30	93

* - Хүлцэх хэм хэмжээ,

** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2018 оны эхний 10 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 226 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 10.6 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 36.2 хувийг газрын зөрчил, 16.8 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 4.8 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 6.2 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, геодези зураг зүй, кадастр зөрчил 14.6 хувийг тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 149.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 9. Байгаль орчны зөрчил, төрлөөр, эхний 10 сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2017			2018		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	146	166	57.0	504	226	149.8
Ой	15	10	3.8	14	7	3.0
Ан, амьтан	12	8	1.9	26	8	0.7
Газрын	11	37	25.3	191	82	35.8
Ус	7	-	1.1	11	4	7.1
Ургамал, хөрсний бохирдол	11	14	3.1	15	14	3.8
Агаар, химийн хорт бодис	11	21	5.0	56	11	15.2
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	18	17	5.5	86	24	16.3
Геодези зураг зүй, кадастр	12	27	1.4	56	33	18.1
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	6	-	-	38	38	48.5
Бусад	43	32	9.9	11	5	1.3



ГЭМТ ХЭРЭГ

2018 оны эхний 10 сард 22422 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4688 (26.4%) хэргээр өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 24.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.9 пунктээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 4418 хүн гэмтэж осолдон, 339 хүн нас барж, төр ард иргэдэд 121.2 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 18.3 тэрбум (15.1%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 38.2 хувийг хулгайн, 22.6 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 17.3 хувийг залилан, 5.6 хувийг дээрмийн, 2.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.4 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.1 хувийг хүчин, 1.0 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 10.2 хувийг бусад гэмт хэрэг түс түс эзэлж байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, эхний 10 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2018/2017	
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 257	17 734	22 422	4 688	35.0
Хүний амь	67	81	82	1	101.2
Хүчин	121	168	250	82	148.8
Дээрэм	318	763	1 261	498	165.3
Хулгай	5 245	6 918	8 564	1 646	123.8
Булаалт	133	52	- ⁵	-	-
Залилан	1 635	2 049	3 886	1 837	189.7
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	4 141	4 253	5 069	816	119.2
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	799	650	456	-183	70.2
Бусдыг амиа хорлоход хүргэх	115	381	232	-177	60.9
Ашиглах	171	164	308	147	187.8
Танхайрах	1 029	586	34	-549	5.5
Бусад	1 483	1 669	2 280	512	336.6

Хүснэгт 11. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 10 сард


Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2018/2017	
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	15 257	17 734	22 422	4 688	126.4
Багануур	251	220	216	-4	98.2
Багахангай	20	32	23	-9	71.9
Баянгол	2 704	2 434	3 905	1 471	160.4
Баянзүрх	3 519	4 793	6 659	1 866	138.9
Налайх	417	377	383	6	101.6
Сонгинохайрхан	2 440	3 196	3 160	-36	98.9
Сүхбаатар	2 497	2 980	3 789	809	127.1
Чингэлтэй	2 028	2 215	2 372	157	107.1
Хан-Уул	1 381	1 487	1 915	428	128.8

⁵ Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бусдын эд хөрөнгийг булаах гэсэн үзүүлэлтийг гэмт хэргийн бүртгэлд тооцохгүй болсон.

Хүснэгт 12. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2018 оны эхний 10 сард

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон	
Нийслэлийн дүн	21 772	5 369	24.7
Багануур	184	95	51.6
Багахангай	19	2	10.5
Баянгол	3 815	836	21.9
Баянзүрх	6 508	1 329	20.4
Налайх	358	129	36.0
Сонгинохайрхан	3 033	1 003	33.1
Сүхбаатар	3 683	751	20.4
Чингэлтэй	2 315	728	31.4
Хан-Уул	1 857	496	26.7

Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүрэг, хувиар



2018 оны эхний 10 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 17646 (78.6%) нь хөнгөн хэрэг, 4776 (21.3%) нь хүнд хэрэг байна.⁶

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хамгийн өндөртэй (51.6%) дүүрэг нь Багануур байгаа бол илрүүлэлтийн хувь хамгийн доогуур үзүүлэлттэй (10.5%) нь Багахангай дүүрэг байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 6933 болж, өмнөх оны мөн үеэс 705 (9.2%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1432 (20.7%) нь согтуугаар, 862 (12.4%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 370 (5.3%) нь хүүхэд, 1076 (15.5%) нь эмэгтэйчүүд байна.

⁶ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

Хүснэгт 13. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 10 сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2016 I-X	2017 I-X	2018 I-X
Нийслэлийн дүн	5 245	6 918	8 564	4 569	6 014	7 068
Багануур	63	64	61	51	53	57
Багахангай	3	5	6	2	2	6
Баянгол	735	600	1 281	603	459	959
Баянзүрх	1 294	2 104	2 842	1 101	1 819	2 164
Налайх	130	119	142	121	115	133
Сонгинохайрхан	838	1 375	1 275	763	1 277	1 188
Сүхбаатар	990	1 130	1 454	821	973	1 178
Чингэлтэй	790	943	888	742	844	822
Хан-Уул	402	509	615	365	472	561




НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2018 оны эхний 10 сард 690.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 15.0 тэрбум төгрөгөөр (2.2%) илүү бүрджээ. Төсвийн нийт орлогын 90.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 9.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2018 оны эхний 10 сард нийслэлийн татварын орлого 622.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 7.2 тэрбум төгрөгөөр (1.2%) илүү бүрдсэн бол, татварын бус орлого 68.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 7.7 тэрбум төгрөгөөр (12.8%) тус тус илүү бүрдсэн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 22.1 тэрбум төгрөгөөр илүү бүрдэж харин төлбөр, хураамж төлөвлөснөөс 17.2 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 2.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрджээ.

Зураг 13. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 14. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая төгрөг
Нийт орлого	675 646.5	690 601.0	102.2	14 954.6
Татварын орлого	615 139.4	622 360.5	101.2	7 221.2
Орлогын албан татвар	441 751.1	643 976.9	105.0	22 225.8
Хувь хүний орлогын албан татвар	468 251.1	487 584.4	104.1	19 333.3
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	368 000.0	347 962.7	94.6	-20 037.3
Үйл ажиллагааны орлогын	13 856.0	20 892.4	150.8	70 36.3
Хөрөнгийн орлого	44 791.0	64 923.3	144.9	20 132.2
Хөрөнгө борлуулсны орлогын	7 848.1	11 048.9	140.8	3 200.9
Шууд бус орлого	33 756.0	42 757.1	126.7	9 001.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26 500.0	-23 607.5	89.1	2 892.5
Хөрөнгийн албан татвар	69 488.7	71 756.7	103.3	2 268.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	42 396.4	46 558.4	109.8	4 162.1
Бууны албан татвар	292.3	272.1	93.1	-20.1
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	26 800.0	24 926.0	93.0	-1 874.0
Бусад татвар, төлбөр, хураамж	103 899.6	86 627.0	83.4	-17 272.6
Улсын тэмдэгтийн хураамж	43 817.2	36 353.1	83.0	-7 464.0
Газрын төлбөр	164.2	90.1	54.9	-74.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	11 947.2	11 310.0	94.7	-637.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	38 500.0	30 891.9	80.2	-7 608.1
Усны төлбөр	2 857.0	2 724.9	95.4	-132.1
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	24.0	25.6	106.6	1.6
Нийслэл хотын албан татвар	6 590.0	5143.1	78.0	-1 446.9
Бусад татвар, хураамж	0.0	88.3	-	88.3
Татварын бус орлого	60 507.1	68 240.6	112.8	7 733.4
Нийтлэг татварын бус орлого	56 807.1	59 650.7	105.0	2 843.6
Хүүгийн орлого	700.0	401.4	57.3	-298.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого	18 893.1	10 547.9	55.8	-8 345.2
Торгуулийн орлого	22 353.4	33 958.8	151.9	11 605.4
Түрээсийн орлого	1 340.0	1 444.2	107.8	104.2
Бусад нэр заагдаагүй орлого	13 492.3	13 196.5	97.8	-295.8
Хөрөнгийн орлого	3 700.0	8 589.8	232.2	4 889.8
Өмч хувьчлалын орлого	3 700.0	8 589.8	232.2	4 889.8

Хүснэгт 15. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг


Дүүрэг	Үүнээс:								
	Төсвийн орлого			Татварын орлого			Татварын бус орлого		
	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү
Нийслэлийн дүн	690 601.0	102.2	14 954.6	622 360.5	101.2	-7 221.2	68 240.5	112.8	7 733.4
Багануур	1 616.7	125.5	838.7	838.7	97.3	-23.6	777.9	182.5	351.7
Багахангай	208.2	135.0	54.0	69.4	100.7	0.5	138.8	162.8	53.5
Баянгол	21 117.2	118.4	3 281.6	19 468.5	116.7	2 785.5	1 648.7	143.0	496.2
Баянзүрх	24 887.4	117.3	3 674.1	24 840.5	117.4	3 678.7	46.9	91.7	-4.6
Налайх	1 453.9	119.9	241.2	1 071.9	113.2	124.9	382.0	143.8	116.3
Сонгинохайрхан	12 118.6	147.2	3 883.2	11 081.6	149.2	3 655.7	1 037.8	128.1	227.5
Сүхбаатар	58 257.1	146.8	18 570.9	55 812.5	143.4	16 884.4	2 444.7	322.5	1 686.5
Хан-Уул	28 402.2	129.9	6 530.9	26 364.4	130.0	6 088.3	2 037.8	127.7	442.5
Чингэлтэй	50 214.6	95.5	-2 391.5	48 246.4	96.2	-1 914.3	1 968.2	80.5	-477.2
Хотын шууд	492 325.1	96.2	-19 218.1	434 566.6	94.8	-24 059.0	57 758.5	109.1	4 840.9

2018 оны эхний 10 сард орон нутгийн төсвөөс нийслэл, дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 78.4 хувийг (973.0 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 21.6 хувийг (267.4 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Хүснэгт 16. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг


Дүүрэг	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийслэлийн дүн	690 601.0	1 240 418.3	972 968.0	78.4	-267 450.3	-282 367.0
Багануур	1 616.7	13 366.0	12 323.2	92.2	-1 042.8	-10 706.5
Багахангай	208.2	3 545.9	3 245.4	91.5	-300.5	-3 037.2
Баянгол	21 117.2	62 752.5	57 422.5	91.5	-5 330.0	-36 305.3
Баянзүрх	24 887.4	83 193.8	77 379.9	93.0	-5 813.9	-52 492.5
Налайх	1 453.9	15 544.7	14 437.8	92.9	-1 106.9	-12 983.9
Сонгинохайрхан	12 118.6	70 860.5	66 884.2	94.4	-3 976.4	-54 765.6
Сүхбаатар	58 257.1	83 511.5	77 725.0	93.1	-5 786.5	-19 467.9
Хан-Уул	28 402.2	55 928.0	51 134.2	91.4	-4 793.8	-22 732.0
Чингэлтэй	50 214.6	90 763.5	76 261.0	84.0	-14 502.5	-26 046.6
Хотын шууд	492 325.1	760 951.9	536 154.8	70.5	-224 797.1	-43 829.7

Зураг 14. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн нийт зарлагын 20.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 2.4 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 7.3 хувийг татаас, 34.0 хувийг урсгал шилжүүлэг, 36.3 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.


Зураг 15. Төсвийн орлого, зарлага, сая төгрөг



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 10 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2017 оны эцэстэй харьцуулахад 6.5 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувиар, өмнөх 9 дүгээр сартай харьцуулахад 1.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 16. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2018 оны 10 дугаар сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 6.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 6.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 8.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 16.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 3.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 11.4 хувь, тээврийн үйлчилгээ 7.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 12.0 хувь, боловсролын үйлчилгээ 6.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 2.7 хувь, бусад бараа, үйлчилгээ 2.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 17. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс


Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.2	Энэ бүлгийн бүуралтад хүнсний ногоо 5.6 хувиар, бүх төрлийн кофе, цай, какао 0.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.7	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн өсөлтөд архи, спирт 2.0 хувиар, шар айраг 0.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Хувцас, бөс бараа, гутал	2.2	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн өсөлтөд хөвөн, бөс бараа 0.4 хувиар, бүх төрлийн хувцас 1.7 хувиар, бүх төрлийн гутал 3.9 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	4.0	Энэ бүлгийн өсөлтөд сууц хөлслөгчийн төлсөн бодит түрээс 0.5 хувиар, орон сууцны техникийн болон засвар үйлчилгээ 6.0 хувиар, хатуу түлш 9.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.7	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 0.7 хувиар, шүдний эмнэлгийн үйлчилгээ 4.6 хувиар өссөнтэй шүүд холбоотой байна.
Тээвэр	2.7	Энэ бүлгийн өсөлтөд автомашин, мотоцикл 2.0 хувиар, хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материал 5.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.5	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн өсөлтөд дуу, дүрсийг хүлээн авах, бичлэг хийх, хувилах тоног төхөөрөмж 0.6 хувиар, бичгийн болон зургийн хэрэгсэл 3.3 хувиар өссөн нь нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	0.4	Энэ бүлгийн өсөлтөд гуанз, цайны газрын үйлчилгээ 0.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Бусад бараа, үйлчилгээ	0.5	Бусад бараа, үйлчилгээний өсөлтөд үсчин болон гоо сайхны үйлчилгээ 0.1 хувиар, гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 0.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.

2018 оны 10 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 35.5 хувийнх нь үнэ өсөж, 14.0 хувийнх нь үнэ буурч, 50.5 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Хүснэгт 18. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2017-X</u> 2016-X	<u>2018-X</u> 2017-X	<u>2018-X</u> 2017-XII	<u>2018-X</u> 2018-IX
Ерөнхий индекс	108.2	106.8	106.5	101.2
Хүнсний бараа, ундаа, ус	111.0	104.9	106.2	99.8
Согтууруулах ундаа, тамхи	103.2	108.8	108.0	100.7
Хувцас, бөс бараа, гутал	105.9	101.8	100.9	102.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	113.4	116.7	116.5	104.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.1	105.7	103.8	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.0	116.0	111.4	100.7
Тээвэр	110.5	107.4	107.3	102.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	98.5	99.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	103.2	113.0	112.0	100.5
Боловсролын үйлчилгээ	107.5	106.8	106.8	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	102.4	103.5	102.7	100.4
Бусад бараа, үйлчилгээ	108.2	104.6	102.0	100.5

Зураг 17. Нэг кг будааны дундаж үнэ, төгрөг, X сард




Зураг 18. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, төгрөг, X сард




2018 оны 10 дугаар сард хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалах махны үнэ өмнөх сартай харьцуулахад хонины ястай мах 0.4 хувиар, үхрийн ястай мах 0.8 хувиар тус тус өссөн байна. Өмнөх 9 дүгээр сартай харьцуулахад талх, гурил, будааны бүлгийн үнэ тогтвортой байсан бол харин хүнсний ногооны бүлгийн үнэ 5.6 хувиар буурсан байлаа.


Зураг 19. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, X сард, төгрөг



Зураг 20. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, сард, төгрөг



Зураг 21. Нэг ширхэг өндөгний дундаж үнэ, X сард, төгрөг




Хүснэгт 19. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Төрөл	2015		2016		2017		2018	
	IX	X	IX	X	IX	X	IX	X
	төгрөг							
Тэмээний шир	21 500	21 500	16 500	16 500	12 500	17 500	17 055	7 000
Адууны шир	28 667	35 500	35 000	29 000	18 667	19 333	16 462	10 000
Үхрийн шир	48 333	47 667	30 000	31 667	34 000	33 333	2 6907	13 500
Хонины арьс	1 833	1 500	3 000	2 500	4 000	4 750	3 021	2 150
Ямааны арьс (ноолууртай)	3 667	8 333	1 500	9 750	2 000	17 666	2 000	2 500
Ямааны ноолуур	51 000	51 000	45 000	45 000	75 000	70 000	89 547	80 000

Багануур дүүргийн түүхий эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 450.0 мянган төгрөг, үхэр 750.0 мянган төгрөг, эр хонь 170.0 мянган төгрөг, эм хонь 140.0 мянган төгрөг, ямаа 95.0 мянган төгрөгийн ханштай байв.

Нийслэлийн түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 7000 төгрөг, адууны шир 10000 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 7000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 13500 төгрөг, хонины арьс 2150 төгрөгийн ханштай байна.

Зураг 22. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 20. Нэг кг махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг



Үхрийн мах

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845		


Хонины мах

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440		

Зураг 23. Нэг кг хонины махны дундаж үнэ, төгрөг



Зураг 25. Шатахууны үнэ, төгрөг, өөрчлөлт орсон өдрөөр




Хүснэгт 21. Түлшний үнэ, төгрөг

Байршил	2016.X.26			2017.X.25			2018.X.31		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) 12-14 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) 12-14 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) 12-14 кг
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	1 800	-	2 000	2 200	-	2 700	4 000	-	4 000
Сүхбаатар	1 700	-	2 200	2 000	-	2 600	4 000	-	4 000
Цайз зах	1 800	-	2 000	2 100	2 000	2 500	4 000	3 500	4 000
Хангай зах	1 600	-	2 000	2 200	-	2 600	3 500	3 500	-
Дундаж үнэ	1 725	-	2 050	2 125	2 000	2 600	3 500	3 500	4 000

Хүснэгт 22. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2017.X.25					2018.X.31				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1 820	-	1 630	1 720		1 780	1 950	2 220		
Петровис	1 820	1 480	1 630	1 720		2 345	1 845	1 985	2 385	
Магнай трейд	1 820	1 480	1 630	1 720		2 340	-	1 980	2 380	
Сод монгол	1 820	-	1 630	1 720		2 300	-	1 980	2 380	
Шунхлай	-	-	1 630	1 720		2 320	1 850	1 985	2 385	
Юнигаз					1 050					1 300
Дундаж үнэ	1 820	1 480	1 630	1 720	1 050	2 326	1 825	1 976	2 350	1 300

Зураг 26. Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш, төгрөг⁷



⁷ Мэдээллийн эх сурвалж: Монголбанкны статистикийн мэдээлэл

Хүснэгт 23. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны VIII, IX, X сарын өдрүүдээр

